

**ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ БА АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**

Хэрэгжилтийн явц, үр дүнг Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6 дугаар зүйлд заасны дагуу дүгнэлээ.

**Зорилт 1.1.** "Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэн, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ" гэсэн ерөнхий зорилтын хүрээнд 7 арга хэмжээг (1.1.1-1.1.7) төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан нь SMART зарчмыг онцгой сайн хангасан байна.

- Тоон өсөлт: Хамрагалттай холбоотой 4 арга хэмжээ (1.1.2, 1.1.3, 1.1.4, 1.1.5) бүр төлөвлөсөн зорилтот түвшингээс давж биелсэн. Энэ нь үр дүн тооцох боломжтойг баталгаажуулж, тайланг хэмжигдэхүйц болгосон.
- Нарийвчилсан мэдээлэл: Тайланд зөвхөн хувь биш, харин шинээр ашиглалтад орсон цэцэрлэгийн баг/сумын нэр, хөрөнгө оруулалтын хэмжээ (142.2 сая ₮, 152 сая ₮) зэрэг тодорхой мэдээллийг тусгасан нь тайлангийн найдвартай байдлыг нэмэгдүүлж байна.
- Чанар ба тоо хэмжээний уялдаа: Чанарын удирдлага (1.1.7)-ын хүрээнд 11 удаагийн хөндлөнгийн шалгалт, олон тооны багш, суралцагчдын үнэлгээний мэдээлэл нь хамрагалтын ахиц (1.1.2-1.1.5)-тай зэрэгцэн гарсан нь хийгдсэн ажлын үр нөлөө өндөр байгааг харуулж байна.

Арга хэмжээ бүрээр хэрэгжилтийг үзүүлбэл:

| №     | Арга Хэмжээ / Үзүүлэлт            | Төлөвлөсөн Зорилго (Хүрэх Түвшин) | Хүрсэн Үр Дүн (Тайлан) | Хэрэгжилтийн Хувь (%)             | Дүгнэлт /6.5 заалтын дагуу/ |
|-------|-----------------------------------|-----------------------------------|------------------------|-----------------------------------|-----------------------------|
| 1.1.1 | Салбарын үйл ажиллагаа, удирдлага | 100%                              | 100%                   | $\frac{100\%}{100\%} = 100\%$     | Үр дүнтэй                   |
| 1.1.2 | СӨБ-ын цэвэр жингийн хамрагалт    | 91.8%                             | 92.2%                  | $\frac{92,2\%}{91,8\%} = 100.4\%$ | Үр дүнтэй                   |
| 1.1.3 | 5 настай хүүхдийн СӨБ-д хамрагалт | 96.5%                             | 97.2%                  | $\frac{97,2\%}{96,5\%} = 100.7\%$ | Үр дүнтэй                   |
| 1.1.4 | ЯХТ хүүхдийн СӨБ-д хамрагалт      | 81.3%                             | 82.2%                  | $\frac{82,2\%}{81,3\%} = 101.1\%$ | Үр дүнтэй                   |
| 1.1.5 | ЯХТ хүүхдийн ЕБС-д хамрагалт      | 75.5%                             | 80%                    | $\frac{80,0\%}{75,5\%} = 105.9\%$ | Үр дүнтэй                   |
| 1.1.6 | Гэнэтийн үеийн бэлэн байдал       | 100%                              | 100%                   | $\frac{100\%}{100\%} = 100\%$     | Үр дүнтэй                   |
| 1.1.7 | Үнэлгээ, шалгалтын удирдлага      | 100%                              | 100%                   | $\frac{100\%}{100\%} = 100\%$     | Үр дүнтэй                   |

Тоон үзүүлэлтүүдийн дундаж үр дүн (6.7 заалтын дагуу)

$$\frac{100\% + 100.4\% + 100.7\% + 101.1\% + 105.9\% + 100\% + 100\%}{7} = 101.1\%$$

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээний аргачлалын дагуу:

- Хэрэгжилтийн Явц (6.5): Зорилт 1.1-ийн хүрээнд тоон үзүүлэлттэй болон үйл ажиллагааны бүх арга хэмжээний хэрэгжилтийн явц нь зорилтот түвшний 85.0 хувь буюу түүнээс дээш байна.
- Дүгнэлт (6.5.1): Боловсролын Зорилт 1.1-ийн хэрэгжилтийн үр дүн нь "Үр дүнтэй"

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

- Ерөнхий Дундаж (6.7): Зорилт 1.1-ийн нийт хэрэгжилтийн дундаж (тоон үзүүлэлтүүдээр) нь 101.35% байна.

#### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дорнод аймгийн боловсролын салбар 2025 онд Зорилт 1.1-ийн хүрээнд төлөвлөсөн бүх арга хэмжээний зорилго буюу 100%-ийн хэрэгжилтийн үзүүлэлтийг бүрэн хангасан бөгөөд хамрагдалттай холбоотой тоон үзүүлэлтүүдийг давж биелүүлсэн байна.

##### 1. Хамрагдалтын Ахиц (1.1.2 - 1.1.5):

- Тэгш хамруулах боловсрол (ЕБС): Хамгийн том ахиц нь 1.1.5 арга хэмжээ буюу ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ЕБС-д хамрагдалт төлөвлөсөн 75.5%-иас 80%-д хүрч, 9.4%-ийн өсөлт үзүүлсэн.
- Цэвэр жин, 5 настай хүүхэд: СӨБ-ын цэвэр жин (92.2%) болон 5 настай хүүхдийн хамрагдалт (97.2%) хоёулаа төлөвлөсөн зорилгоо давсан нь шинэ цэцэрлэг, хувилбарт сургалтын үр дүнг харуулж байна.

##### 2. Удирдлага ба Бэлэн Байдал (1.1.1, 1.1.6, 1.1.7):

- Энэ чиглэлийн бүх арга хэмжээний зорилго 100% байсан бөгөөд бүрэн хэрэгжсэн. Ялангуяа, багш, суралцагчдын үнэлгээнд (1.1.7) олон тооны хөндлөнгийн шалгалт, үнэлгээ зохион байгуулж, үр дүнд нь дүн шинжилгээ хийсэн нь чанарын удирдлага сайн түвшинд байгааг илтгэж байна.

**Зорилт 1.2.** " Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ." гэсэн ерөнхий зорилтын хүрээнд 11 арга хэмжээг (1.2.1-1.2.11) төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан нь SMART зарчмыг өндөр түвшинд хангасан байна.

##### 1. Давуу Талууд (Тайлангийн Чанар) Тодорхой (S) ба Хэмжигдэхүйц (M): Тайланд арга хэмжээ бүрийн үр дүн тоо, хувь, мөнгөн дүн-ээр (Жишээ нь, 1.2.4-т 7.6 тэрбум ₮; 1.2.9-т 100% хамрагдалт) маш тодорхой, хэмжигдэхүйцээр илэрхийлэгдсэн.

Нотолгоо (R): Хэрэгжүүлсэн ажлын цар хүрээ (Жишээ нь, 1.2.6-т 11534 хүнд мэдээлэл өгсөн; 1.2.7-д 14824 хүүхэд хамрагдсан) болон санхүүгийн эх үүсвэрийг (Жишээ нь, 1.2.7-д нийт 318.1 сая ₮) дэлгэрэнгүй дурдсан нь тайлангийн найдвартай байдлыг нэмэгдүүлж байна.

##### 2. Анхаарах Асуудлууд (Тайлан дахь Гүйцэтгэлийн Эрсдэл) Тайлангийн чанар сайн байгаа хэдий ч, хэд хэдэн арга хэмжээнд гүйцэтгэлийн эрсдэл (R/T) үүссэн нь тодорхой байна:

- 1.2.2 (Дотуур Байр): Хоёр барилга хоёулаа (Цагаан-Овоо, Баян-Уул) санхүүжилт болон гэрээний асуудлаас үүдэн ашиглалтад орох хугацаа хойшилсон. Энэ нь БГ-ын хяналтаас гадуурх хүчин зүйлээс шалтгаалан хугацаа (Т)-нд хүрэхгүй байгааг харуулж байна.
- 1.2.3 (АЦБ): Гүйцэтгэл 60% байгаа ажилд гэрээ цуцлах санал хүргүүлсэн нь ажлын гүйцэтгэл зогсох эрсдэлтэйг илтгэж байна.

| №     | Арга Хэмжээ / Үзүүлэлт   | Төлөвлөсөн Зорилго (Хүрэх Түвшин) | Хүрсэн Үр Дүн (Тайлан)                         | Хэрэгжилтийн Хувь (%)            | Дүгнэлт /6.5 заалтын дагуу/ |
|-------|--------------------------|-----------------------------------|------------------------------------------------|----------------------------------|-----------------------------|
| 1.2.1 | Сургууль, цэцэрлэг барих | 1 цэцэрлэг                        | 1 цэцэрлэг                                     | $\frac{1}{1} \times 100 = 100\%$ | Үр дүнтэй                   |
| 1.2.2 | Дотуур байрны барилга    | 2 дотуур байр                     | Ашиглалтад ороогүй 2 барилгын гүйцэтгэл 80-90% | $\frac{0}{2} = 0\%$              | Үр дүнгүй                   |

#### Эх сурвалж: А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

|        |                                                        |                                                          |                                               |                                                                                                       |           |
|--------|--------------------------------------------------------|----------------------------------------------------------|-----------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| 1.2.3  | Ариун Цэврийн Байгууламж (АЦБ)                         | Жилийн эцэг: 2 сургууль, цэцэрлэг                        | 1 Сургуулийн АЦБ ашиглалтад орсон             | $\frac{1}{4} \times 100 = 25\%$                                                                       | Үр дүнгүй |
| 1.2.4  | Хүүхдүүдийн суралцах орчин нөхцөл                      | Жилийн эцэг: 16                                          | 20 төсөл хэрэгжсэн                            | $\frac{20\%}{16\%} = 125\%$                                                                           | Үр дүнтэй |
| 1.2.5  | Сурах бичгийн ашиглалт                                 | Жилийн эцэг: 90                                          | 86.3%                                         | $\frac{86.3\%}{90\%} = 95.8\%$                                                                        | Үр дүнтэй |
| 1.2.6  | Дунд, бага сургуулийн барилга                          | Жилийн эцэг: 7 сургалт, нөлөөллийн ажил                  | 11 сургалт, 11534 хүн хамрагдсан              | $\frac{11}{7} = 157\%$                                                                                | Үр дүнтэй |
| 1.2.7  | “Өдөр бүр Сүү”                                         | Жилийн эцэг: СӨБ-31, ЕБС-22 байгууллагад хэрэгжсэн байна | 53 байгууллага, 14824 хүүхэд                  | $\frac{53}{53} = 100\%$                                                                               | Үр дүнтэй |
| 1.2.8  | Орчны стандартын шаардлага хангасан цэцэрлэг, сургууль | Жилийн эцэг: СӨБ - 48.3 ЕБС-45.3                         | СӨБ-96.7, ЕБС-77.3                            | $\frac{96.7\%}{45.3\%} = 213\%$<br>$\frac{77.3\%}{45.3\%} = 170\%$<br>$\frac{213\%+170\%}{2} = 191\%$ | Үр дүнтэй |
| 1.2.9  | Урьдчилан сэргийлэх үзлэг                              | Жилийн эцэг: 100                                         | Багш, ажилтан 100% суралцагч 90,5% хамрагдсан | $\frac{100\%}{100\%} = 100\%$<br>$\frac{90,5\%}{100\%} = 90,5$<br>$\frac{100\%+90.5\%}{2} = 95.25\%$  | Үр дүнтэй |
| 1.2.10 | “Эрүүл Шүд” (Шүд угаах цэг)                            | Жилийн эцэг: 3                                           | 8 шүд угаах цэг бий болсон                    | $\frac{8}{5} \times 100 = 160\%$                                                                      | Үр дүнтэй |
| 1.2.11 | Ундны усны төхөөрөмж                                   | Жилийн эцэг: 26                                          | 26 байгууллага                                | $\frac{100\%}{100\%} = 100\%$                                                                         | Үр дүнтэй |

Тоон үзүүлэлтүүдийн дундаж үр дүн (6.7 заалтын дагуу)

$$\frac{100\%+0\%+25\%+125\%+95.8\%+157\%+100\%+191\%+95.25\%+160\%+100\%}{11} = 93.1\%$$

Бодлогын хэрэгжилтийг үнэлэх журмын дагуу, Зорилт 1.2-ын 11 арга хэмжээний үр дүнг нэгтгэвэл:

- Үр дүнтэй (8 Арга Хэмжээ) 1.2.1, 1.2.2, 1.2.4, 1.2.5, 1.2.8, 1.2.9, 1.2.10, 1.2.11 арга хэмжээнүүд нь зорилтот түвшингээ 85% болон түүнээс дээш хувьтай биелүүлсэн тул "Үр дүнтэй" гэж дүгнэгдэж байна. Ялангуяа 1.2.8, 1.2.10 нь төлөвлөснөөс хамаагүй өндөр үр дүн үзүүлжээ.
- Үр дүн гараагүй (2 Арга Хэмжээ) 1.2.2 (Дотуур байрны барилга) 0%, 1.2.3 (АЦБ-ын угсралт) арга хэмжээний биелэлт ЗТ-ийн 25%-д хүрсэн тул 6.5.4-р заалтын дагуу "Үр дүн гараагүй" гэж дүгнэгдэж байна. Энэ нь дэд бүтцийн томоохон ажил төлөвлөгөөний дагуу хэрэгжээгүй байгааг харуулж байна.
- Онцгой нөхцөл: 1.2.2 арга хэмжээнд ашиглалтад орохоор төлөвлөсөн 2 барилгын 85%, 1.2.3 арга хэмжээнд ашиглалтад орохоор төлөвлөсөн 4 ариун цэврийн байгууламжаас 3 60%-ийн гүйцэтгэлтэй хэдий ч, ажил зогссон нь 6.2-р заалтын дагуу сөрөг өөрчлөлт бөгөөд энэ нь эцсийн үр дүнг (ашиглалтад оруулах) хугацаа алдахад хүргэсэн.

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Зорилт 1.2-ын хүрээнд Боловсролын газар нь үйл ажиллагаа, эрүүл мэнд, стандартын хэрэгжилт зэрэг шууд удирдаж чадах чиглэлээр маш өндөр амжилт гаргаж, зорилтот түвшинг давуулан биелүүлсэн.

Харин хөрөнгө оруулалт, санхүүжилт, гүйцэтгэгчээс шалтгаалсан байгууллагаас үл шалтгаалах объектив шалтгаануудаар эрсдэлүүд үүсч, 1.2.2, 1.2.3 арга хэмжээний биелэлт хангагдаагүй нь зорилтын хэрэгжилтэд нөлөөлжээ.

1.2.2, 1.2.3 нь Боловсролын газар нь бүрэн удирдаж чадахуйц бус арга хэмжээ хэдий ч байгууллагын зүгээс гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэлийн эрсдэлийг тодорхойлж, холбогдох дээд байгууллагад гэрээ цуцлах санал уламжлах, хамтарсан хяналт хийх зэрэг өөрсдөөс шалтгаалах боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

### ТАВ. ЗӨВЛӨМЖ

Энэ зорилтын хүрээнд Боловсролын газар нь бусад байгууллага, хөрөнгө оруулалт болон эрх зүйн шийдвэрээс хамааралтай 9 арга хэмжээг төлөвлөсөн байв. Цаашид зорилтот түвшинг эцсийн үр дүнгээр (барилга ашиглалтад оруулах) бус, харин БГ-ын шууд удирдаж, хянаж чадах гарц болон үйл явцын чанараар тодорхойлох нь зүйтэй.

**Зорилт 3.1.** Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ. гэсэн ерөнхий зорилтын хүрээнд 8 арга хэмжээг (3.1.1-3.1.8) төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан нь SMART зарчмыг өндөр түвшинд хангасан байна

- Төлөвлөлтийн үед байсан Хэмжигдэхүйц (M), Хүрэхүйц (A), Үр дүнд чиглэсэн (R) тал дээрх эргэлзээ, эрсдэлүүдийг тайлангийн мэдээллээр бүрэн баталгаажуулж, нөхөж чадсан.
- Тайланд зөвхөн гүйцэтгэлийн хувь (гарц) бус, мөн чанарын өөрчлөлт (үр дүн/Outcome) -ийг илэрхийлэх үзүүлэлтүүдийг (мэдлэг, чадварын ахиц) тусгасан нь Бодлогын Үнэлгээний Журмын 6.2-р заалтын шаардлагыг (гарцын нөлөөгөөр бий болсон өөрчлөлт) хангаж байна.
- Тайлан нь төлөвлөлтийн үе шатанд дутагдаж байсан шаардлагуудыг нөхөж, SMART зарчмыг бүрэн хангасан, чанартай мэдээлэл өгсөн байна.

Арга хэмжээ бүрээр хэрэгжилтийн үр дүнг үзүүлбэл:

| №     | Арга Хэмжээ /<br>Үзүүлэлт                     | Төлөвлөсөн<br>Зорилго (Хүрэх<br>Түвшин)                             | Хүрсэн Үр<br>Дүн (Тайлан)                                           | Хэрэгжилтийн<br>Хувь (%)                                                                      | Дүгнэлт<br>/6.5<br>заалтын<br>дагуу/ |
|-------|-----------------------------------------------|---------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|
| 3.1.1 | Төлөвшлийн<br>ажиллагаа үйл                   | 100%                                                                | 100%                                                                | $\frac{100\%}{100\%} = 100\%$                                                                 | Үр<br>дүнтэй                         |
| 3.1.2 | Секц, дугуйлан                                | 12500 суралцагч                                                     | 20722 суралцагч                                                     | $\frac{20722}{12500} = 165.8\%$                                                               | Үр<br>дүнтэй                         |
| 3.1.3 | Өөрийн удирдлагын<br>байгууллага              | 2300 суралцагч                                                      | 2496 суралцагч                                                      | $\frac{2496}{2300\%} = 108.5\%$                                                               | Үр<br>дүнтэй                         |
| 3.1.4 | Элсэлтийн шалгалт                             | 100%                                                                | 100%                                                                | $\frac{100\%}{100\%} = 100\%$                                                                 | Үр<br>дүнтэй                         |
| 3.1.5 | Цахим сургуулийн<br>ирц                       | 75%                                                                 | 75%                                                                 | $\frac{100\%}{100\%} = 100\%$                                                                 | Үр<br>дүнтэй                         |
| 3.1.6 | Байгалийн ухаан<br>туршилтын багаж<br>хангамж | Туршилтын багаж<br>хэрэглэгдэхүүнийг<br>нэмэгдүүлсэн<br>сургууль -2 | Туршилтын багаж<br>хэрэглэгдэхүүнийг<br>нэмэгдүүлсэн<br>сургууль -2 | $\frac{2}{2} = 100\%$<br>$\frac{3260}{2600} = 125.4\%$<br>$\frac{100\%+125.4\%}{2} = 112.7\%$ | Үр<br>дүнтэй                         |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

|       |                    |                                                            |                                                     |                               |           |
|-------|--------------------|------------------------------------------------------------|-----------------------------------------------------|-------------------------------|-----------|
|       |                    | Судлан шинжлэх чадвараа хөгжүүлсэн суралцагч - 2600 /нийт/ | Судлан шинжлэх чадвараа хөгжүүлсэн суралцагч - 3260 |                               |           |
| 3.1.7 | Хүүхэд хамгаалал   | 100%                                                       | 100%                                                | $\frac{100\%}{100\%} = 100\%$ | Үр дүнтэй |
| 3.1.8 | Эцэг эхийн сургалт | 100%                                                       | 100%                                                | $\frac{100\%}{100\%} = 100\%$ | Үр дүнтэй |

Тоон үзүүлэлтүүдийн дундаж үр дүн (6.7 заалтын дагуу)

$$\frac{100\% + 165.8\% + 108.5\% + 100\% + 100\% + 112.7\% + 100\% + 100\%}{8} = 110.8\%$$

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээний аргачлалын дагуу:

- Хэрэгжилтийн Явц (6.5): Зорилт 3.1-ийн хүрээнд тоон үзүүлэлттэй болон үйл ажиллагааны бүх арга хэмжээний хэрэгжилтийн явц нь зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш байна.
- Дүгнэлт (6.5.1): Боловсролын Зорилт 3.1-ийн хэрэгжилтийн үр дүн нь "Үр дүнтэй"
- Ерөнхий Дундаж (6.7): Зорилт 3.1-ийн нийт хэрэгжилтийн дундаж (тоон үзүүлэлтүүдээр) нь 110.8% байна.

#### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Зорилт 3.1-ийн хүрээнд төлөвлөгдсөн хүүхдийн хөгжил, авьяас, хүүхэд хамгааллын чиглэлээр тавьсан зорилтоо бүрэн биелүүлж, бүх 8 арга хэмжээ нь 100%-аас дээш гүйцэтгэлтэй буюу "Үр дүнтэй" гэж дүгнэгдсэн нь Боловсролын газрын үйл ажиллагааны үр нөлөөг тодотгож байна.

- Хамгийн өндөр гүйцэтгэлтэй арга хэмжээ нь 3.1.2 (Хичээлээс гадуурх дугуйланд хамрагдалт) 165.8%, 3.1.6 (Байгалийн ухааны туршилтын багаж, хэрэглэгдэхүүний хангалтыг нэмэгдүүлэх, суралцагчдын судлан шинжлэх, арга барилыг дэмжих арга хэмжээ) 112.7%
- Гарц ба Үр Нөлөө: Хэдийгээр арга хэмжээнүүд ихэвчлэн гарцад чиглэсэн байсан ч, тайланд үр нөлөөний зарим тооцоог (жишээ нь, 3.1.1-д мэдлэг 88-93% ахисан, 3.1.2-т чадвар 30.4-40.1% ахисан, 3.1.6-д судлан шинжлэх чадвар 6.7 нэгжээр өссөн) тусгасан нь чанарын өөрчлөлт гарч байгааг харуулж байна.

#### 2. Төлөвлөлтийн эрсдэл ба бодит Биелэлт

Төлөвлөлтийн үе шатанд 3.1.2 ба 3.1.3 зэрэг арга хэмжээний санхүүжилт нь Салбарын Санхүүжилт (САЗХ)-ээс хамааралтай тул хүрэхүйц (А) байдалд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн хэдий ч эдгээр арга хэмжээний гүйцэтгэл зорилто түвшинг давж биелсэн (3.1.2 нь 165.8%, 3.1.3 нь 108.5) нь санхүүжилтийн асуудал үүсээгүй, эсвэл бусад эх үүсвэрээр нөхөгдсөнийг илтгэж байна.

#### ЗӨВЛӨМЖ:

Зорилт 3.1-ийн хэрэгжилт маш өндөр байгаа тул, цаашид Боловсролын газар нь:

1. Үр дүнгийн үнэлгээг бэхжүүлэх: 3.1.1, 3.1.2, 3.1.6 арга хэмжээнүүдэд тусгагдсан мэдлэг, чадварын ахиц дэвшлийг хэмжих үр нөлөөний шалгуурыг албан ёсны зорилтот түвшин болгон төлөвлөгөөнд тогтмол тусгах.
2. Эрсдэл тооцох: Ирэх жилийн төлөвлөгөөнд санхүүжилтээс хамаарах төслүүдийн бодит эх үүсвэрийн баталгааг төсөв батлагдахтай зэрэгцүүлэн нарийвчлан тусгах.

**Зорилт 3.2.** Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшилийг дэмжихэд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ. гэсэн

Эх сурвалж: А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Емэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

ерөнхий зорилтын хүрээнд 8 арга хэмжээг (3.2.1-3.2.8) төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан нь SMART шаардлагыг бүрэн хангасан байна.

- Санхүүгийн үр нөлөөг тодорхойлсон: төсөл, уралдаанаар дамжуулан багш нарын нийгмийн баталгаанд (орон сууц, зээл) бодит, тооцоологдсон (20 сая төгрөг) дэмжлэг үзүүлсэн мэдээлэл нь хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилтын үр дүнг шууд илэрхийлж байна.
- Үр дүнгийн үзүүлэлт: Зөвхөн сургалтад хамрагдсан тоог (гарц) бус, харин багшийн мэргэшлийн зэргийн өсөлт, байгууллагын үнэлгээний ахиц зэрэг чанарын үзүүлэлтүүдийг тусгасан нь тайланг чанартай, үр дүнтэй болгосон.

Арга хэмжээ бүрээр хэрэгжилтийн үр дүнг үзүүлбэл:

| №     | Арга Хэмжээ / Үзүүлэлт                                                                                                                                                                    | Төлөвлөсөн зорилго (Хүрэх түвшин) | Хүрсэн үр дүн Тайлан)                                   | Хэрэгжилтийн Хувь             | Дүгнэлт /6.5 заалтын дагуу/ |
|-------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|---------------------------------------------------------|-------------------------------|-----------------------------|
| 3.2.1 | “Багшийн 3 тулгуурт бодлого” цогц арга хэмжээний хүрээнд “Эрдэм” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.                                                                                    | 100%                              | 100%                                                    | $\frac{100\%}{100\%} = 100\%$ | Үр дүнтэй                   |
| 3.2.2 | Цэцэрлэг сургуулийн менежментийг сайжруулахад арга зүйн дэмжлэг үзүүлнэ.                                                                                                                  | СӨБ-6, ЕБС-8                      | СӨБ-15, ЕБС-14 (нийт 29 байгууллага д дэмжлэг үзүүлсэн) | $\frac{29}{14} = 207.1\%$     | Үр дүнтэй                   |
| 3.2.3 | Мэргэжлийн хөгжлийн бүлгээр багшлахуйг дэмжин ажиллана.                                                                                                                                   | 100%                              | 100%                                                    | $\frac{100\%}{100\%} = 100\%$ | Үр дүнтэй                   |
| 3.2.4 | “Зөвлөх багшийн манлайлал” арга хэмжээг хэрэгжүүлж, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.                                                                                                  | 37 багш                           | 61 багш, удирдах ажилтан                                | $\frac{61}{37} = 164.9\%$     | Үр дүнтэй                   |
| 3.2.5 | Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх, тэдэнд холбогдох хууль тогтоомжид заасан нэмэгдэл, урамшуулал олгоно. | 100%                              | 100%                                                    | $\frac{100\%}{100\%} = 100\%$ | Үр дүнтэй                   |
| 3.2.6 | “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд “Цэцэрлэгийн багш” цэцэрлэгийн багш нарын дунд болзолт уралдааныг зохион байгуулж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.                   | 4 багш                            | 9 багш                                                  | $\frac{9}{4} = 225\%$         | Үр дүнтэй                   |
| 3.2.7 | “Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд “Бага ангийн багш”-ийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ.                                                   | 28 багш                           | 28 багш                                                 | $\frac{100\%}{100\%} = 100\%$ | Үр дүнтэй                   |
| 3.2.8 | Багш удирдах ажилтны мэдээлэл холбооны технологи ашиглах чадвар, цахим контент бэлтгэх мэдлэг, ур чадварыг                                                                                | 2 багш хөгжлийн төв               | 2 багш хөгжлийн төв, 3                                  | $\frac{5}{2} = 250\%$         | Үр дүнтэй                   |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

|  |                                                                                               |  |                      |  |  |
|--|-----------------------------------------------------------------------------------------------|--|----------------------|--|--|
|  | дээшлүүлэх, ажлын байран дээрээ хөгжих орчныг бүрдүүлэх, “Багш хөгжлийн төв”-ийг нэмэгдүүлнэ. |  | мэдээлэл зүйн танхим |  |  |
|--|-----------------------------------------------------------------------------------------------|--|----------------------|--|--|

Тоон үзүүлэлтүүдийн дундаж үр дүн (6.7 заалтын дагуу)

$$\frac{100\%+207.1\%+100\%+164.9\%+100\%+225\%+100\%+250\%}{8} = 155.8\%$$

8

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээний аргачлалын дагуу:

- Хэрэгжилтийн Явц (6.5): Зорилт 3.2-ын хүрээнд тоон үзүүлэлттэй болон үйл ажиллагааны бүх арга хэмжээний хэрэгжилтийн явц нь зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш байна.
- Дүгнэлт (6.5.1): Боловсролын Зорилт 3.2-ын хэрэгжилтийн үр дүн нь "Үр дүнтэй"
- Ерөнхий Дундаж (6.7): Зорилт 3.2-ын нийт хэрэгжилтийн дундаж (тоон үзүүлэлтүүдээр) нь 155.8% байна. Зорилтыг 55%-аар давж биелүүлсэн бөгөөд багшийн мэргэжлийн хөгжил болон нийгмийн баталгааг хангах чиглэлд маш сайн үр дүн гарсан болохыг харуулж байна.

#### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

"Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмж, нийгмийн баталгааг хангана" гэсэн үндсэн зорилтоо 100%-ийн гүйцэтгэлээр биелүүлж, "Үр дүнтэй" гэж дүгнэгдэж байна.

Арга хэмжээнүүдийн төлөвлөгөөг давсан гүйцэтгэл нь дараах эерэг өөрчлөлтүүдийг бий болгосон байна. Үүнд:

- Мэргэжлийн дэмжлэг нэмэгдэж, байгууллагын чанар өссөн: Төлөвлөснөөс 2 дахин олон (нийт 29) байгууллагууд (3.2.2) менежментийн сайжруулалт, арга зүйн дэмжлэг авч, СӨБ-ын үнэлгээ 3.08-аар, ЕБС-ийн үнэлгээ 7.9-өөр өссөн.
- Багшийн манлайлал өргөжсөн: "Зөвлөх" зэрэгтэй багш 22-оор, "Тэргүүлэх" зэрэгтэй багш 51-ээр нэмэгдсэн. Зөвлөх багшийн оролцоог 65%-иар нэмэгдүүлж, 61 зөвлөх багш туршлагаа түгээсэн (3.2.4).
- Нийгмийн баталгааг бодитоор хангасан: Нийт 37 багш, ажилтан (4 багш +28 багш) орон сууц, зээл, урамшуулал хэлбэрээр 20 сая төгрөг хүртэлх бодит дэмжлэг үзүүлсэн (3.2.6).
- Хөдөлмөрийн бүтээмжийн орчин сайжирсан: 274.0 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжөөр хангагдсан.

**Зорилт 3.3.** Мэргэжлийн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэн, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ гэсэн ерөнхий зорилтын хүрээнд 4 арга хэмжээг (3.3.1-3.3.4) төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан нь SMART шаардлагыг бүрэн хангасан байна

- Хамран сургалт, хөдөлмөр эрхлэлт, элссэн суралцагчийн тоо, хамрагдсан иргэдийн тоо зэрэг нь тодорхой тоо, хувиар илэрхийлэгдсэн тул хэмжигдэхүйц байсан нь гүйцэтгэлийг тодорхой дүгнэх үндэс болсон
- Тайланд дурдсан бүх арга хэмжээ нь Зорилт 3.3-ын үндсэн зорилго болох мэргэжлийн боловсролын чанар, тэгш боломжийг дээшлүүлэхэд шууд хамааралтай.
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 67.1%-д хүрсэн, 58 сурагч тэргүүлэх/эрэлттэй мэргэжлээр их дээд сургуульд элссэн, 39 сурагч тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан зэрэг нь үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх гэсэн үндсэн зорилтын бодит үр дүнг илэрхийлнэ.
- Бүх үйл ажиллагаа Жилийн эцэст хэмжигдэхээр төлөвлөгдсөн бөгөөд тайлант хугацаандаа амжилттай хэрэгжиж дууссан.

Арга хэмжээ бүрээр хэрэгжилтийн үр дүнг үзүүлбэл:

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

| №     | Арга хэмжээ / Үзүүлэлт                                                                                                                                                                                                 | Төлөвлөсөн зорилго (Хүрэх Түвшин) | Хүрсэн үр дүн (Тайлан) | Хэрэгжилтийн Хувь (%)                                                                               | Дүгнэлт /6.5 заалтын дагуу/ |
|-------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------|
| 3.3.1 | Мэргэжлийн боловсрол, сургалтад хамрагдалтыг нэмэгдүүлнэ. /14–65 насны хүн амд эзлэх хувь/                                                                                                                             | 2,3%                              | 2.02%                  | $\frac{2.02\%}{2.3\%} = 87.8\%$                                                                     | Үр дүнтэй                   |
| 3.3.2 | Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч болон төгсөгчийг ажлын байртай холбох ажлыг орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулна.                  | 63.3%                             | 67.1%                  | $\frac{67.1}{63.3\%} = 106\%$                                                                       | Үр дүнтэй                   |
| 3.3.3 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагаа, зөвлөх үйлчилгээ зохион байгуулна.<br>- Хамрагдагсан суралцагч, эцэг эхийн тоо<br>- Эрэлттэй болон тэргүүлэх чиглэлээр элсэн суралцсан суралцагчдын тоогоор | 16000<br><br>176                  | 19112<br><br>58        | $\frac{19112}{16000} = 119.45\%$<br>$\frac{58}{176} = 40\%$<br>$\frac{119.45\% + 40\%}{2} = 79.7\%$ | Үр дүнтэй                   |
| 3.3.4 | Их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, бүх шатны сургалтын байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, үйл ажиллагааг дэмжинэ.                                                                                 | 100%                              | 100%                   | $\frac{100\%}{100\%} = 100.0\%$                                                                     | Үр дүнтэй                   |

Тоон үзүүлэлтүүдийн дундаж үр дүн (6.7 заалтын дагуу)

$$\frac{87.8\% + 106\% + 79.7\% + 100\%}{4} = 93.3\%$$

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээний аргачлалын дагуу:

- Хэрэгжилтийн Явц (6.5): Зорилт 3.3-ын хүрээнд тоон үзүүлэлттэй болон үйл ажиллагааны бүх арга хэмжээний хэрэгжилтийн явц нь зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш байна.
- Дүгнэлт (6.5.1): Боловсролын Зорилт 3.3-ын хэрэгжилтийн үр дүн нь "Үр дүнтэй"
- Ерөнхий Дундаж (6.7): Зорилт 3.3-ын нийт хэрэгжилтийн дундаж (тоон үзүүлэлтүүдээр) нь 93.3% байна.

#### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

3.3 нь 93.3 хувийн дундаж гүйцэтгэлтэйгээр “Үр дүнтэй” (Журам 6.5.1) гэж дүгнэгдэж байна. Мэргэжлийн боловсролын хамран сургалт, хөдөлмөр эрхлэлт болон чиг баримжаа олгох үйл ажиллагааны чанарын үзүүлэлтүүд амжилттай биелсэн нь өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх үндсэн зорилгыг хангасан.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнг гарцын нөлөөгөөр бий болсон эерэг өөрчлөлтөөр гарсан байна.

- Хөдөлмөр эрхлэлт сайжирсан: Политехник коллежийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь төлөвлөсөн 63.3%-иас давж 67.1%-д хүрсэн. Энэ нь үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх зорилт биелж буйн тод илрэл юм.

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

- Хувийн хэвшлийн оролцоо: 27 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулж, 80 оюутан цалинтай дадлага гүйцэтгэсэн. Мөн 20 байгууллага 24 төгсөгчийг шууд ажлын байранд авч ажиллуулсан нь сургалт, хөдөлмөрийн зах зээлийн холбоо бэхэжсэнийг илтгэж байна.
- Тэгш Боломж Өргөжсөн: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг 568 удаа зохион байгуулж, нийт 19,112 сурагч, эцэг эх, иргэнийг хамруулсан нь (3.3.3) хүрэхүйц болон үр дүнд чиглэсэн байдлыг баталгаажуулж байна.

**Зорилт 3.4.** Насан туршийн боловсролын суралцахуйн бодлогыг хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийг сурч хөгжих тэгш боломж олгоно гэсэн ерөнхий зорилтын хүрээнд 3 арга хэмжээг (3.4.1-3.4.3) төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан нь SMART шаардлагыг маш сайн хангасан байна.

- Арга хэмжээ бүр тодорхой үйл ажиллагаанд чиглэсэн: Боловсрол нөхөн олгох хөтөлбөр, Цахим ур чадвар олгох сургалт, Амьдралын чадварт нөлөөлөх сургалтууд.
- Үр дүн тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэн: 32 суралцагч боловсрол нөхөн олгох сургалтад хамрагдсан. 5122 иргэн цахим ур чадварын сургалтад хамрагдсан.
- Үйл ажиллагаа нь насан туршийн боловсрол, иргэдэд тэгш боломж олгох үндсэн зорилготой шууд нийцсэн. Цахим ур чадварыг дээшлүүлж, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулсан. Хүүхэд залуусыг санхүүгийн боловсрол, цахим залилангаас урьдчилан сэргийлэх сургалтад хамруулсан.
- Арга хэмжээнүүд нь 2024-2026 оны хичээлийн жилд болон I, II, III, IV улиралд үргэлжлэхээр төлөвлөгдсөн бөгөөд тайлангаар үр дүнгээ гаргасан.

Арга хэмжээ бүрээр хэрэгжилтийн үр дүнг үзүүлбэл:

| №     | Арга хэмжээ / Үзүүлэлт                                                                                               | Төлөвлөсөн зорилго (Хүрэх Түвшин) | Хүрсэн үр дүн (Тайлан) | Хэрэгжилтийн Хувь (%)           | Дүгнэлт /6.5 заалтын дагуу/ |
|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|------------------------|---------------------------------|-----------------------------|
| 3.4.1 | Хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн олгох, суралцуулах ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана. | 33 суралцагч                      | 32                     | $\frac{33}{32} = 97.0\%$        | Үр дүнтэй                   |
| 3.4.2 | Цахим ур чадвар олгох сургалт зохион байгуулна.                                                                      | 1600                              | 5122                   | $\frac{5122}{1600} = 320\%$     | Үр дүнтэй                   |
| 3.4.3 | Бүх насны иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.                                      | 100%                              | 100%                   | $\frac{100\%}{100\%} = 100.0\%$ | Үр дүнтэй                   |

Тоон үзүүлэлтүүдийн дундаж үр дүн (6.7 заалтын дагуу)

$$\frac{97\% + 320\% + 100\%}{4} = 172.3\%$$

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээний аргачлалын дагуу:

- Хэрэгжилтийн Явц (6.5): Зорилт 3.4-ийн хүрээнд тоон үзүүлэлттэй болон үйл ажиллагааны бүх арга хэмжээний хэрэгжилтийн явц нь зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш байна.
- Дүгнэлт (6.5.1): Боловсролын Зорилт 3.4-ийн хэрэгжилтийн үр дүн нь "Үр дүнтэй"
- Ерөнхий Дундаж (6.7): Зорилт 3.4-ийн нийт хэрэгжилтийн дундаж (тоон үзүүлэлтүүдээр) нь 172.3% байна.

**ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

Зорилт 3.4-ийн бүх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн бөгөөд ялангуяа цахим ур чадвар олгох чиглэлээр маш өндөр үр дүнд хүрсэн байна.

- Боловсрол Нөхөн Олголт: 2024-2025 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр 39 суралцагч суралцсанаас суурь боловсролд 9, бүрэн дунд боловсролд 13 суралцагч боловсролын гэрчилгээ авсан нь боловсролын тэгш боломжийг хангасан.
- Цахим Ур Чадвар: Төлөвлөсөн 1600 иргэнээс 5122 иргэнийг цахим ур чадварын сургалтад хамруулсан нь насан туршийн боловсролын хүртээмжийг 3.2 дахин нэмэгдүүлснийг харуулж байна.
- Мэргэжлийн Сургалт: Нягтлан бодох бүртгэл, малчны чадамжийн гэрчилгээ олгох, англи хэлний сургалт зэрэг амьдралын чанарт нөлөөлөх сургалтуудад иргэдийг хамруулсан.

**Зорилт 3.5.** Мэргэжлийн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэн, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ гэсэн ерөнхий зорилтын хүрээнд 4 арга хэмжээг (3.5.1-3.5.5) төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан нь SMART шаардлагыг маш сайн хангасан гэж дүгнэгдэж байна.

- Тайлан нь зөвхөн хийгдсэн ажлын тоо (хяналт шалгалтын тоо, хамрагдсан объект) буюу гарцыг хэмжээд зогсохгүй, бодит үр дүнг тоон үзүүлэлтээр илэрхийлсэн.
- Үр Дүнгийн Нотолгоо: Эрсдэлийн түвшин буурсан, хоолны аюулгүй байдлын шаардлага хангахгүй бүтээгдэхүүнийг татан авалт хийлгэсэн зэрэг нь тэгш хүртээмжтэй байх нөхцөлийг бодитойгоор хангаж буйг харуулсан.

Арга хэмжээ бүрээр хэрэгжилтийн үр дүнг үзүүлбэл:

| №     | Арга хэмжээ / Үзүүлэлт                                                                                                                                                                                                               | Төлөвлөсөн зорилго (Хүрэх Түвшин)     | Хүрсэн үр дүн (Тайлан)                            | Хэрэгжилтийн хувь (%)                                  | Дүгнэлт /6.5 заалтын дагуу/ |
|-------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------|---------------------------------------------------|--------------------------------------------------------|-----------------------------|
| 3.5.1 | Боловсролын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийнэ.                                                                                                                            | 9 объект<br>36.5%<br>эрсдэлийн түвшин | 9 объект<br>21%                                   | $\frac{9}{9} = 100.0\%$<br>$\frac{21}{36,5} = 142.5\%$ | Үр дүнтэй                   |
| 3.5.2 | Салбарын хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ.                                                                                                                                                                | 4 чиглэл<br>100%                      | 4 чиглэл<br>100%                                  | 100%                                                   | Үр дүнтэй                   |
| 3.5.3 | Өмчийн бүх хэлбэрийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийн, зөвлөн тусалж, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.                                                                                     | СӨБ-14 ЕБС-14 нийт 28 байгууллага     | СӨБ-14 цэцэрлэг, ЕБС-9 сургууль, дотуур байр -23  | $\frac{23}{28} = 82.1\%$                               | Үр дүнтэй                   |
| 3.5.4 | Боловсрол, сургалтын байгууллага, дотуур байранд орчны эрсдэлийн үнэлгээг хийж, орчны аюулгүй байдлын стандарт, эрүүл ахуйн стандарт болон дотуур байрын орчин, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангахад хяналт тавин ажиллана. | СӨБ-14 ЕБС-14 нийт 28 байгууллага     | СӨБ-32 цэцэрлэг, ЕБС-27 сургууль, дотуур байр -16 | $\frac{61}{28} = 217.8\%$                              | Үр дүнтэй                   |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Емэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

|       |                                                                                                                                      |   |   |                         |           |
|-------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---|-------------------------|-----------|
| 3.5.5 | Мэргэжлийн байгууллагатай хамтран цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлд, үйлчилгээнд хүнс нийлүүлж байгаа аж ахуй нэгжид хяналт хийх | 7 | 7 | $\frac{7}{7} = 100.0\%$ | Үр дүнтэй |
|-------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---|-------------------------|-----------|

Тоон үзүүлэлтүүдийн дундаж үр дүн (6.7 заалтын дагуу)

$$\frac{121.2+100\% + 82.1\% + 217.8\%+100\%}{5} = 124.2\%$$

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээний аргачлалын дагуу:

- Хэрэгжилтийн Явц (6.5): Зорилт 3.5-ын хүрээнд тоон үзүүлэлттэй болон үйл ажиллагааны 4 арга хэмжээний хэрэгжилтийн явц нь зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш буюу “үр дүнтэй”, 1 арга хэмжээ 82.1 буюу “үр дүн хүлээгдэж байгаа” гэж дүгнэлээ.
- Ерөнхий Дундаж (6.7): Зорилт 1.1-ийн нийт хэрэгжилтийн дундаж (тоон үзүүлэлтүүдээр) нь 124.2% байна.

#### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Зорилт 3.5-ын хүрээнд хэрэгжсэн үйл ажиллагааны хамрагдалт болон үр дүн нь төлөвлөгөөнд заасан зорилтот түвшинг ихээхэн давж биелүүлсэн байна. Хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ болон орчны эрсдэлийн үнэлгээний хамрагдалт нь зорилтот түвшнээс 2–2.8 дахин давж хэрэгжсэн. Үр дүнгийн чанар нь эрсдэлийн түвшин зорилтот түвшингээс 15.5 хувиар буурсан нь тэгш хүртээмжтэй, аюулгүй орчинг бүрдүүлэхэд бодит үр дүн гарсан байна.

**Зорилт 4.1** Бүх шатны төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэн, иргэд олон нийтэд төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй хүргэнэ ерөнхий зорилтын хүрээнд 6 арга хэмжээг (4.1.1-4.1.6) төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан нь SMART шаардлагыг сайн хангасан байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан нь SMART шаардлагыг сайн хангасан байна. Ихэнх арга хэмжээний (4.1.1-4.1.5) зорилтот түвшинг 100% гэж төлөвлөсөн байсан бөгөөд биелэлтийг шууд тоо баримтаар болон гүйцэтгэсэн ажлын цар хүрээгээр баталж тайлагнасан байна.

Арга хэмжээ бүрээр хэрэгжилтийн үр дүнг үзүүлбэл:

| №     | Арга хэмжээ / Үзүүлэлт                                                                                                                                                                     | Төлөвлөсөн зорилго (Хүрэх Түвшин) | Хүрсэн үр дүн (Тайлан) | Хэрэгжилтийн Хувь (%) | Дүгнэлт /6.5 заалтын дагуу/ |
|-------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|------------------------|-----------------------|-----------------------------|
| 4.1.1 | Сургууль, цэцэрлэг, Боловсрол, шинжлэх ухааны газарт иргэдээс ирсэн санал, өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд бүрэн шийдвэрлэнэ.                                                             | 100%                              | 100%                   | 100%                  | Үр дүнтэй                   |
| 4.1.2 | Албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, сахилга хариуцлагыг сайжруулах олон талт арга хэмжээ авч ажиллана.                                                                     | 100%                              | 100%                   | 100%                  | Үр дүнтэй                   |
| 4.1.3 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйгээр хангана.                                                   | 100%                              | 100%                   | 100%                  | Үр дүнтэй                   |
| 4.1.4 | Ерөнхий боловсрол, хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн боловсролын байгууллагын хэвийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, тогтмол зардлын өр үүсгэхгүй | 100%                              | 100%                   | 100%                  | Үр дүнтэй                   |

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Емэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

|       |                                                                                                                                                                                                |                            |                            |      |           |
|-------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------|----------------------------|------|-----------|
|       | байх, барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний зардлыг хуваарилан хэрэгжүүлнэ.                                                                                      |                            |                            |      |           |
| 4.1.5 | Боловсролын салбарын төсвийн шинэчлэл, цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагааг дэмжиж ажиллах, холбогдох тооцоо судалгаа, цахим төсвийн төслийн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулна. | 100%                       | 100%                       | 100% | Үр дүнтэй |
| 4.1.6 | Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангана                                                        | БДБ-75 маягт, СӨБ-27 маягт | БДБ-75 маягт, СӨБ-27 маягт | 100% | Үр дүнтэй |

Тоон үзүүлэлтүүдийн дундаж үр дүн (6.7 заалтын дагуу)

$$\frac{100\%+100\% + 100\%+100\%+100\%+100\%}{6} = 100\%$$

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээний аргачлалын дагуу:

- Хэрэгжилтийн Явц (6.5): Зорилт 4.1-ийн хүрээнд тоон үзүүлэлттэй болон үйл ажиллагааны бүх арга хэмжээний хэрэгжилтийн явц нь зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш байна.
- Дүгнэлт (6.5.1): Боловсролын Зорилт 4.1-ийн хэрэгжилтийн үр дүн нь "Үр дүнтэй"
- Ерөнхий Дундаж (6.7): Зорилт 4.1-ийн нийт хэрэгжилтийн дундаж (тоон үзүүлэлтүүдээр) нь 100% байна.

#### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Зорилт 4.1-ийн зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. Үүнд: Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт маш өндөр (100%-д ойр) байгаа нь төрийн үйлчилгээний хариуцлагатай байдлыг харуулна. Ёс зүйн байгууллагыг шинэчилж, багш, ажилтнуудыг хамруулан тангараг өргөх, сургалт, олон нийтийн арга хэмжээ зэргээр дамжуулан сахилга хариуцлагыг бэхжүүлсэн. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх төлөвлөгөөг бүх байгууллагаас авч, хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Төсвийн гүйцэтгэл ил тод явагдсан. Төсвийн мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулсан. Багш ажилтнуудын урамшуулал, тэтгэмжийг журмын дагуу олгосон. Боловсролын газрын зүгээс төсвийн зарлагын гүйцэтгэл 87.7%-тай байгаа нь санхүүжилт бүрэн олгогдохгүй байгаагаас үүдэлтэй тул, энэ нь БГ-ын гүйцэтгэлийн доголдол биш, харин төсвийн гүйцэтгэлийн гадаад шалтгаантай асуудал юм. Боловсролын Газрын зүгээс санхүүжилт олгох эрх бүхий дээд шатны байгууллагуудад өглөг үүссэн шалтгаан, нөхцөл байдлыг тогтмол, албан ёсоор мэдээлж, санхүүжилтийг нэн даруй нөхөн олгох асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг уламжлан ажиллаж байгаа нь маш зөв менежментийн алхам юм. Зорилт 4.1.4 нь Ажлын гүйцэтгэлээр 100% буюу "Үр дүнтэй" гэж үнэлэгдэх нь оновчтой.

#### ЗӨВЛӨМЖ:

- Мэдээлэл солилцоо: ЗДТГ, Санхүүгийн хэлтэст өглөгийн нийт хэмжээ, үүссэн хугацаа, үр дагавар (жишээлбэл, дулаан хангамжид үүсэх эрсдэл) зэрэг мэдээллийг тогтмол, үр дагаврыг нь тодруулж мэдээлэх.
- Нөөц төлөвлөгөө: Ийм нөхцөлд байгууллагуудын үйл ажиллагааг (ялангуяа тогтмол зардал: цахилгаан, дулаан) тасалдуулахгүй байх нөөц төлөвлөгөөг боловсруулж, урьдчилан сэргийлэх.

**Зорилт 4.2.** Хүнд суртлаас урьдчилан сэргийлэх ерөнхий зорилтын хүрээнд 4 арга хэмжээг (4.2.1-4.2.4) төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан нь SMART шаардлагыг сайн хангасан байна. Үйл ажиллагаа нь авлига, хүнд суртлаас урьдчилан

Эх сурвалж: А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

сэргийлэх, төрийн үйлчилгээг ил тод болгох үндсэн зорилготой шууд нийцсэн. Авлигын эсрэг ажлын тоо (ЗТ-2, ХТ-4), ХАСХОМ мэдүүлэг гаргасан албан хаагчдын тоо (ЗТ-108, ХТ-108) зэргээр тоон үзүүлэлт тодорхой. Бүх арга хэмжээ I-IV улиралд хэрэгжихээр төлөвлөгдсөн ба, тайлант хугацаандаа амжилттай хэрэгжиж дууссан.

Арга хэмжээ бүрээр хэрэгжилтийн үр дүнг үзүүлбэл:

| №     | Арга хэмжээ / Үзүүлэлт                                                                                                                                                                                                                                                                         | Төлөвлөсөн зорилго (Хүрэх Түвшин) | Хүрсэн үр дүн (Тайлан) | Хэрэгжилтийн Хувь (%)           | Дүгнэлт /6.5 заалтын дагуу/ |
|-------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|------------------------|---------------------------------|-----------------------------|
| 4.2.1 | Авлигатай тэмцэх, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу урьдчилан сэргийлэх арга чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулна.                                                                 | 4                                 | 4                      | $\frac{4}{4} = 200.0\%$         | Үр дүнтэй                   |
| 4.2.2 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.                                                                                                   | 108                               | 108                    | $\frac{108}{108} = 100\%$       | Үр дүнтэй                   |
| 4.2.3 | Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч нартай байгуулах үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан үүргээ гүйцэтгэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэгт холбогдохгүй байх заалт болон хэрэгжүүлэх арга хэмжээг тусган үр дүнг тооцон ажиллах | 53                                | 54                     | $\frac{54}{53} = 101.9\%$       | Үр дүнтэй                   |
| 4.2.4 | Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх                                                                                                                   | 58                                | 58                     | $\frac{100\%}{100\%} = 100.0\%$ | Үр дүнтэй                   |

Тоон үзүүлэлтүүдийн дундаж үр дүн (6.7 заалтын дагуу)

$$\frac{100\%+100\%+101.9\% + 100\%}{4} = 100.5\%$$

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээний аргачлалын дагуу:

- Хэрэгжилтийн Явц (6.5): Зорилт 4.2-ын хүрээнд тоон үзүүлэлттэй болон үйл ажиллагааны бүх арга хэмжээний хэрэгжилтийн явц нь зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш байна.
- Дүгнэлт (6.5.1): Боловсролын Зорилт 4.2-ын хэрэгжилтийн үр дүн нь "Үр дүнтэй"
- Ерөнхий Дундаж (6.7): Зорилт 4.2-ын нийт хэрэгжилтийн дундаж (тоон үзүүлэлтүүдээр) нь 100.5% байна.

**ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Эмэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089

Зорилт 4.2-ын хэрэгжилт нь 100 хувийн дундаж гүйцэтгэлтэйгээр “Үр дүнтэй” (Журам 6.5.1) гэж дүгнэгдэж байна. Энэ нь хүнд суртлаас урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах зорилтууд төлөвлөсөн хэмжээнээс өндөр хувьтай хэрэгжсэн болохыг харуулж байна. Хоолны хангамж болон байгууллагын гүйцэтгэлийн гэрээнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх заалтуудыг бүрэн тусгасан нь үйл ажиллагааг ил тод, хуулийн дагуу болгох гол алхам болсон. Удирдах болон бусад албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг 100% бүрдүүлж, баталгаажуулсан.

#### ЗӨВЛӨМЖ

- Авлигын эсрэг нөлөөллийн ажлын зорилтот түвшинд хүрсэн сайн туршлагыг хадгалж, дараагийн жилийн төлөвлөгөөнд Авлигын эсрэг нөлөөллийн зорилтот түвшинг нэмэгдүүлэх
- Хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх заалтууд гэрээнд туссан ч, цаашид тус гэрээний хэрэгжилтэд бодит хяналт шалгалтыг нэмэгдүүлж, авлигын эрсдэлийг бүрэн арилгахад анхаарах

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН

АХЛАХ АРГА ЗҮЙЧ



А.МӨНХЖАРГАЛ

**Эх сурвалж:** А.Мөнхжаргал

Дорнод аймгийн Боловсролын газар

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот

Статистикийн мэдээлэл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч

Емэйл: [munkhjargal6lqv@moes.edu.mn](mailto:munkhjargal6lqv@moes.edu.mn) Утас: 89336089